



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№116 /560/

2023.07.28

Цаг үе, үйл явдал

Г.БОЛОР: МАНЛАЙЛАГЧ БАЙХ НЬ АЛБАН ТУШААЛ ЭРХ МЭДЭЛТЭЙ БАЙХЫН НЭР БИШ



нийтлэг зарчим, агуулгыг тодорхойлохын зэрэгцээ төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлж, нийгэмд эерэг хандлага түгээж, зөв үлгэр дуурайлал үзүүлэх хүрээнд санал солилцсон юм.

Энэ үеэр ЗХЖШ-ын СБГ-ын дарга бригадын генерал Г.Болор залуу офицеруудад хандаж хэлсэн үгэндээ "төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудад баримтлах цэргийн манлайллын тулгуур баримт бичиг боловсруулах ажил дуусах шатандаа орсон. Энэхүү баримт бичиг нь төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын бие бүрэлдэхүүний манлайллын сэтгэлгээг нэгтгэж, үнэт зүйл, үзэл санаа, зарчмын нэгдмэл ойлголттой болоход зүг чиг нь болно гэж найдаж байна. Товчхондоо манлайлагч байх нь албан тушаал эрх мэдэлтэй байхын нэр биш. Бусдад урам зориг өгч, тэднийг гэрэлт ирээдүй өөд хөтлөх чадвартай байх явдал" болохыг онцлов.

Үргэлжлүүлэн ХХЕГ-ын Захиргааны удирдлага эрхэлсэн дэд дарга бригадын генерал Д.Мөнгөнжин оролцогчдод хандаж үг хэлсэн юм. Тэрээр "хийж бүтээх, шинийг санаачлах залуу насны эрч хүч, урам зоригоор дүүрэн залуусыг харах сайхан байна. Хил хамгаалах байгууллага та бүгдийг гуравхан зүйлд уриалан дуудахыг хүсэж байна. Нэгдүгээрт бид бүгд харилцан бие биесээ хүндэтгэж сурах хэрэгтэй.

Хоёрдугаарт бусдыг хайрлах, энэрэх ухаанд суралцаасай. Гуравдугаарт бусдыг зөв замд уриалан дуудах нөлөөлөгч байгаасай гэж хүсэж байна. Дээрх гуравхан зүйлд суралцаж чадсан цагт бид нэгэн зүгт харж хөгжихийн зэрэгцээ нийгэмд манлайллын тухай ойлголтыг өөрсдийн биеэр үлгэрлэх болно" гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлэв.

Чуулга уулзалтаар "Төрийн албаны манлайлал ба үнэт зүйл", "Манлайллын тухай ойлголт", "Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын хөгжилд бидний оролцоо ба манлайлал" сэдвийн хүрээнд илтгэл хэлэлцүүлж төгсөлд нь "Төрийн тусгай алба хаагчдын манлайллын зарчим, агуулга" ба "Хамтын ажиллагааны зарим асуудал" сэдэвт нэгдсэн хэлэлцүүлэг хийж залуу офицерууд санал бодлоо хуваалцлаа.



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч У.Хүрэлсүх 2023 оныг "Залуу офицеруудын жил" болгон зарласан. Үүнтэй холбогдуулан БХЯ, ЗХЖШ-аас залуу офицеруудыг дэмжих хүрээнд олон ажил, арга хэмжээг шат дараатайгаар хэрэгжүүлсээр байна.

Тэгвэл энэ удаа ЗХЖШ, ХХЕГ-тай хамтран төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын гадаадын цэргийн академи, их дээд сургууль төгссөн залуу офицеруудын чуулга уулзалтыг зохион байгууллаа.

Чуулга уулзалтад төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын төлөөлөл болсон 72 залуу офицер оролцож төрийн тусгай алба хаагчдын манлайллын

ЦЭРГИЙН ЁСЛОЛЫН ЖАГСААЛ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Ардын засгийн жилүүдэд анхлан байгуулагдсан 4 аймгийн нэг нь Цэцэрлэг мандал уулын аймаг буюу эдүгээгийн Архангай аймаг билээ. Архангай аймаг үүсэн байгуулагдсаны 100 жилийн ой энэ өдрүүдэд тохиож байна.

Ойг тэмдэглэх арга хэмжээний хүрээнд Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын 11 жагсаалын хайрцаг 300 гаруй алба хаагч оролцсон цэргийн ёслолын жагсаал БНМАУ-ын маршал Г.Дэмидийн нэрэмжит тайлбайд зохион байгуулагдлаа. Засгийн газрын шийдвэрээр тус аймагт байгуулагдсан барилга инженер, экологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах Зэвсэгт хүчний Барилга, инженерийн цэргийн удирдах газрын харьяа 342 дугаар ангийн бие бүрэлдэхүүн энэхүү ёслолын жагсаалд шинэхэн хүлээж авсан байлдааны тугтайгаар оролцлоо.

Түүнчлэн аймгийн төвийг алган дээр тавьсан мэт харагдуулах Сангийн толгойд Цэцэрлэг хотын хоймроо дүнхийн ханхайх Булган уулыг тахиx ёслолыг Төгсбаясгалант хийдийн хуваргууд зохион байгууллаа.

БРИГАДЫН ГЕНЕРАЛ Д.БААСАНДАМБА ОЮУТАН ЦЭРГҮҮДИЙН СУРГАЛТ БЭЛТГЭЛИЙН ЯВЦТАЙ ТАНИЛЦЛАА



Монгол Улсын Ерөнхийлөгчийн аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх бригадын генерал Д.Баасандамба БНМАУ-ын баатар, ЗХУ-ын 4 удаагийн баатар, Маршал Г.К.Жуковын нэрэмжит Зэвсэгт хүчний 327 дугаар ангид ажиллаж байна.

Энэ үеэр тус ангийг түшиглэн явагдаж байгаа оюутан цэргийн сургалтын төвийн өдөр тутмын үйл ажиллагаа, цагийн хуваарь, ар тал ахуй

хангалт, хоолны амт чанар, цэргийн байр, хотхоны зохион байгуулалттай танилцаж, түрүүч, байлдагч нартай уулзлаа.

Мөн "Оюутан цэрэг-2023" цэргийн мэргэжил олгох сургалтад цэргийн хэргийн мэдлэг, дадлага, сургалт бэлтгэлээр бусдыгаа манлайлсан зарим байлдагч нарт цол гардууллаа. Түрүүч цолоор Г.Шандас, А.Азжаргал, дэд түрүүч цолоор

Б.Сүлдбаяр, Б.Цэлмэг, Э.Дөлгөөн, А.Төрболд, ахлах байлдагч цолоор Г.Хүрэлзүрх, О.Энхжавхлан, С.Чинтөгс, М.Сүхсайхан нарт олгогдсоныг гардуулан өгч баяр хүргэв.

Төгсгөлд нь албаа үлгэр жишээ хааж байгаа оюутан цэргийн төлөөлөл болгож түрүүч Г.Шандаст бригадын генерал Д.Баасандамба зүүж явсан бугуйн цагаа дурсгалаа.

Хошууч Д.ГАНБААТАР



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
19	11

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
30	21

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,429	3,437
EUR	3,800	3,830
CNY	480	487
RUB	38.10	38.30
JPY	24	25.10
KRW	2.65	2.69

ЗУРХАЙ

2023.07.28 /БААСАН ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 10

ЗУНЫ АДАГ ШАРАГЧИН ХОНЬ
САР
ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ
УЛААГЧИН ГАХАЙ ӨДӨР

Үс засуулбал:
Эрч хүч ихэснэ
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
05.23-20.34
Барилдлага:
Шид
Шүтэн барилдлага:
Төрөн түгэхүй

Тухайн өдөр хонь, бич, тахиа, могой, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр аливаа үйлс сэтгэлчлэн бүтнэ. Шүтээн босгох, хот балгадыг барих, тариа тарих, худалдаа наймаа хийх, шид бүтээл үйлдэх тарни тоолох болон дэлгэрүүлэх үйл бүхнээ сайн болой, хувцас хийх, гэр орон барих, сан нуун дарахад сайн.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 691,800,775

Эдгэрсэн

Нийт: 664,400,741

Нас барсан

Нийт: 6,904,005

Цахим шууданд

“ТУНГАЛАГ МЭЛМИЙ–2023” АРГА ХЭМЖЭЭ АМЖИЛТТАЙ БОЛЖ ӨНДӨРЛӨЛӨӨ



талархал илэрхийлье.

“Тунгалаг мэлмий–2023” хүмүүнлэгийн арга хэмжээнд хамрагдсан хүмүүсийн ярианаас энэ арга хэмжээ нэн чухал болох нь харагдаж байлаа. Ирэх жил үзүүлэх хүмүүсийнхээ тоог ахиулах хүсэлтийг бид Солонгосын талд тавьсныг тэд хүлээн авсныг дуулгахад таатай байна.

Харин ахмадуудаа үзүүлэх байгууллагууд өгсөн тоонд багтаан эхний ээлжид нэн шаардлагатай хүмүүсээ хамруулах талаар анхаарах шаардлагатай байна.

Манай улсад нүдний эрүүл мэнд бас л тулгамдсан асуудлын нэг болж магадгүй талаар мэргэжлийн хүмүүс ярьж байв.

МНЦХ

Монгол цэргийн нэгдсэн холбоо БНСУ-ын Нүдний шилний нийгэмлэгийн гишүүдтэй хамтран Улаанбаатар хот, Орхон Хөвсгөл аймгуудад “Тунгалаг мэлмий–2023” хүмүүнлэгийн арга хэмжээ зохион байгуулж, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчид, ахмад дайчид, орон нутгийн иргэдийн төлөөлөл зэрэг 600 орчим хүнд нүдний харааны оношилгоо хийж, харааны шил тааруулан үнэ төлбөргүй олгосны зэрэгцээ 1500 гаруй нарны шилийг иргэдэд тарааж өглөө. Бидний очиж ажилласан газар бүр орон нутгийн удирдлага чин сэтгэлийн дэмжлэг үзүүлж хамран ажилласанд гүн



“ХАНХӨХИЙН ГАВЬЯАТ ХУРАНДАА” ХЭМЭЭХ БҮТЭЭЛ ХЭВЛЭГДЭН ГАРЛАА



Алс баруун хязгаар Ханхөхийн нутгийн малчин ардын ууган хүү Монгол Улсын гавьяат барилгачин, Ардын армийн хурандаа Манкадайн Мөнхбатын “ХАНХӨХИЙН ГАВЬЯАТ ХУРАНДАА” дурсамж, дурдатгал ном уншигч та бүхний гар дээр очиход бэлэн боллоо.

“Бурхан хүнийг бүтээсэн. Бусдыг нь барилгачид бүтээдэг” гэсэн сайхан үгийг бодит амьдралд бүтээлчээр хэрэгжүүлж, “Бурхантын хөндий”-д найрамдлаар овоглосон “Дархан хот”-ыг бүтээн байгуулах ажлыг оройлон удирдсан авьяаслаг зохион байгуулагч, удирдагчийн дурсамж, туршлага төдийгүй Дорнод Монголын тал нутаг, Дархан, Эрдэнэтийн бүтээн байгуулалт, Барилга-инженерийн цэргийн зарим хороо, ангиудын дайчин замналыг өгүүлэх энэхүү ном нь “Найрамдлын дархан” хотын түүхэн хуудсыг архивын баримт, нотолгоонд тулгуурлан товч боловч тодорхой харуулахыг хичээсэн, цэргийн болон хөдөлмөрийн хамт олныг удирдахад залуу дарга /захирагч/ нар юунд анхаарах, тулгамдсан асуудлыг хэрхэн шийдвэрлэж байх зэрэг түүх, судалгаа, арга туршлагын цогц бүтээл болсон юм.

Номын баяр 08 дугаар сарын 01-ний өдөр 13.00 цагт Барилга-инженерийн цэргийн удирдах газрын Хурлын зааланд зохион байгуулагдахаар бэлтгэл ажил хангагдаад байна. Дэлгэрэнгүй мэдээллийг 89160954, 99160954, 91160954 утсаар лавлана уу.

Хошууч М.ХИШИГБАЯР

Гэрэл зураг түүх өгүүлнэ



1948 ОНЫ УЛСЫН БАЯР НААДАМ

Тонгойж үг солин дараа нь энгэрийн халааснаасаа 100 төгрөг хурдан морь унаач хүүд гарган өгч байна. БНМАУ-ын хошой баатар, Удирдагч төр нийгмийн нэрт зүтгэлтэн, Өрлөг жанжин Хорлоогийн Чойбалсан.

ОЮУТАН ЦЭРГҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭЭ



Зэвсэгт хүчний 167 дугаар ангийг түшиглэн явагдаж байгаа говийн бүсийн аймгуудын “Оюутан цэрэг-2023” цэргийн мэргэжлийн бэлтгэл шатны сургалтад хамрагдаж буй дайчдын нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор энэ сарын 28-ны өдөр Өмнөговь аймгийн Улаан Загалмайн хороотой хамтран “Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх нь”, “Эмнэлгийн анхан шатны тусламж” сэдэвт хичээлд хамрууллаа.


Энэ нь оюутан цэргүүдийн сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах талаар Зэвсэгт хүчний Жанжин штабаас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд явагдсан ажил юм. Сургалтын хүрээнд оюутан цэргүүд “Монголын Улаан Загалмайн нийгэмлэг”-ийн нийгэмд үзүүлж буй зөв нөлөө, түүний үр дүн, сайн дурын ажилтан байхын давуу талаар мэдээлэл олзворлов. Мөн эрүүл мэндийн боловсролоо нэмэгдүүлж, анхны тусламжийн талаар мэдлэг, дадлага чадвар эзэмшихийн зэрэгцээ “Эрүүл мэнд, эрүүл харилцаа, эрүүл ирээдүй төлөө хамтдаа” уриалгыг дэвшүүллээ.

Ахлах дэслэгч Б.БАТЗАЯА



Уриалга

ЭЛЭГ БҮТЭН ЯВАХ НЬ ЖАРГАЛЫН ДЭЭД ХАНДИВЫН АЯН



БИДНИЙ ХҮҮ Б.ЦЭГЦБИЛИГ нь 2023.05.03 - 07.03 ХООРОНД 3 УДАА ЭХЭМҮТ-Д ХАГАЛГААНД ОРСОН БӨГӨӨД ЭЦСИЙН ОНОШООР ЯСНЫ ХОРТ ХАВДАР /EWING SARCOMA / ГЭСЭН ОНОШТОЙГООР ОДООГ ХҮРТЭЛ ЭХЭМҮТ-Д ЭМЧЛҮҮЛЖ БАЙНА.

ХҮҮД МИНЬ ШААРДЛАГАТАЙ ЭМЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ 588.000.000 СЯ ТӨГРӨГИЙН ДЭМЖЛЭГЭЭР ХЯТДЫН ГУАНЖУ ХОТОД ЭМЧЛЭХ БҮРЭН ЭДГЭРЭХ БОЛОМЖТОЙ. ҮҮНД: ХИМИЙН БОЛОН ТУЯА ЭМЧИЛГЭЭ ҮЕ ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ХАГАЛГАА ХИЙГДЭНЭ.

ХӨӨРХӨН ҮРИЙГ МИНЬ НАРТ ХОРВООД ДАХИН АМЬДРУУЛЖ ТУСЛААЧ ГЭЖ МОНГОЛЫН АРД ТҮМЭН, ЭРХЭМ НАЙЗ НӨХӨД, ТӨРӨЛ САДАН ТА БҮХНЭЭСЭЭ ХИЧЭЭНГҮЙЛЭН ГҮЙЖ БАЙНА. ӨДӨР БҮР ХҮҮГИЙНХЭЭ ӨВДӨЛТ НЬ ИХСЭЖ, УНТАЖ ЧАДАХГҮЙ БАЙГААГ ХАРААД СУУХ ХЭЦҮҮ, ЗОВИУРАА ТЭСЭН ТЭВЧИЖ ЭДГЭРНЭ ГЭЖ ХҮҮХДИЙН ГЭНЭН СЭТГЭЛЭЭР ААВ, ЭЭЖДЭЭ ИТГЭЖ НАЙДАЖ БАЙГААГ ХАРАХААР ӨРӨВДМӨӨР БАЙНА.ТА БҮХЭН ХАЛУУН СЭТГЭЛЭЭ ДЭЛГЭЖ ХАНДИВЫН ГАРААГАА СУНГАЖ ТУСЛАХЫГ УРИАЛЖ БАЙНА.

ЭЭЖ Н.ЦЭЦЭГСАЙХАН-99722277 ААВ Г.БАТГЭРЭЛ-99983627

ТӨРИЙН БАНК USD ДАНС: 130401862454 ЮАНЬ ДАНС: 130401862455 ХААН БАНК 5096054877

Дарга дэд хурандаа САЙНБОЛДЫН УУГАНБАЯР

ЦАХИМ ХАЯГ Батлан хамгаалах яам Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС "Соёмбо" редакц "Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ. * Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ. * Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018 Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn Утас: 70001029, 3412 (дотуур)